



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 11/2020

Улаанбаатар хот

「Багануур-Ус ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/165 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 13,200,000.0 /арван гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Истана маркийн 21-01 БРА улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Багануур-Ус ОНӨААТҮГ /М.Буддорж/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Багануур-Ус ОНӨААТҮГ /М.Буддорж/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Тушаал авто-2020

115370000511